



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Геологийн төв лаборатори” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч нийт 2,823.9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Геологийн төв лаборатори” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Геологийн төв лаборатори” Төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал (Ө.Оюунбаатар)-т санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Байгууллагын үйлдвэрлэл, эдийн засгийн үр ашгийг сайжруулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын тайланг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдан авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх;

2.6. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг чанд мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэх явдлыг таслан зогсоох;

2.7. “Шүүрт булаг” ХХК-аас авсан 36.0 (гучин зургаан) сая төгрөгийн шаматон тегелийн худалдан авалт нь орлогод авсан гэх баталгаажсан гарын үсэггүй, НӨАТ

• 132001331

падангүй зэрэг эрх зүйн чадамжгүй анхан шатны баримтаар хийгдсэн, төлөвлөгөөнд тусгагдаагүй шууд худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг санаатай хийсэн зөрчил дутагдлаар харагдаж байгаа тул хууль хяналтын байгууллагаар нягтлан шалгуулах;

2.8.Химийн шинжилгээний болон технологи туршилтын гүйцэтгэх ажлыг аливаа эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үүднээс дотоод хяналтыг сайжруулж, дээж хүлээн авах, шинжлэх бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах арга хэмжээ авах;

2.9.Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, сайжруулах;

2.10.Цахим тендерийн үр дүн, гүйцэтгэлийг тухай бүр оруулж хэвшүүлэх;

2.11.Тогтоолын хавсралтад дурдсан үргүй зардал болох 29,400.000 (хорин есөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох;

2.12.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлж ажилласан эрх бүхий албан тушаалтан нарт хууль тогтоомжийн дагуу шийтгэл ногдуулах;

3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах тогтоол, төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасгай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 04...
дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
арга хэмжээний жагсаалт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга		Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	ХААТөлөвлөгөөнөөс гадуур худалдан авсан бараа материал, сэлбэг, хэрэгслэл		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	537,151.02	Сангийн сайдын 2018 оны 261 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах
2	Зөвшөөрөлгүй худалдан авсан үндсэн хөрөнгө		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	218,691.01	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
3	ТБОНӨХөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалт зөрчсөн		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	384,700.00	ТБОНӨХөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
4	Хэрэгцээнээс илүү авсан бараа, материал		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	36,000.00	Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
5	Үндсэн баримтгүй	Гэрээгүй	Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	111,388.52	Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтыг мөрдөж ажиллах,
		Тушаал шийдвэргүй		16,963.00	
		Бүрдэл дутуу		11,227.80	
		Зарцуулалтын тайлан, төсөвгүй		3,529.00	
6	Үргүй зардал		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	29,482.10	Төсвийн тухай хуулийн "25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно." заалтыг мөрдөж ажиллах
7	Батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлсэн зардал		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	1,465,600.00	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан зорилтот түвшингийн үзүүлэлтийг хангаж ажиллах, төсвийн тухай хуулийг мөрдөх
8	Хугацаандаа аваагүй НББ-ийн бодлогын баримт бичиг		Захирал Ө.Оюунбаатар, Ерөнхий ня-бо М.Хоролсүрэн	9,200.00	Гэрээний заалтыг хэрэгжүүлж ажиллах
	Дүн			2,823,932.44	